

МОНГОЛЧУУДЫН БИЕ БИЕНЭЭ ДЭМЖИН ТУСЛАХ УЛАМЖЛАЛТ ХАРИЛЦААНЫ ТУХАЙ АСУУДАЛД

С.Гомбо
Филисофийн ухааны доктор (Ph.D)

Монголчууд үеийн үед эрхэлж ирсэн мал аж ахуйн хөдөлмөр амьдарч идээшсэн газар нутаг, байгаль, цаг уур онцлогтойгоо салшгүй холбоотой өвөрмөц соёл, аж байдал, зан заншилтай ард түмэн гэдгийг гадаад дотоодын эрдэмтэд судлаачид сонирхон судалж байсан нь нэн их юм. Энэ бүхний тухай эс өгүүлэн аливаа улс орны хүн зоньхоо оронд ердийн ухамсрын түвшинд үүсэн хөгжиж уламжлагдаж байдаг олон талт харилцааны салшгүй нэгэн хэсэг нь болох бие биенээ харилцан дэмжиж туслах үйл ажиллагаа монголчуудын хувьд ямар онцлогтой байсан бэ гэдгийг эл бэсрэг өгүүлэлд товч атугай ч хөндөж тавихыг зорилго болгов.

Байгаль цаг уурын эрс тэс уур амьсгалтай, зам, харилцаа холбоо хөгжөөгүй энэ өргөн уудам нутагт бэлчээрийн мал аж ахуйг эрхлэн хэдэн мянган үеийг элээсэн монголчууд бидний ахуй амьдрал соёл иргэншил бол суурин соёл иргэншлээс үнэхээрийн өвөрмөц ялгаатай юм. Энэ талаар Ж.Самбуу, Н.Жагварал, Р.Индраа, Ш.Нацагдорж, Х.Пэрлээ, Л.Балдандаш, Х.Нямбуу, С.Бадамхатан гэх мэт олон арван эрдэмтэд, судлаачдын бүтээлд тусгагдсан байдаг.

Монголчуудыг өргөн уудам нутагт нягтрал багатай тархай бутархай амьдардгаас нь болоод гаднаас нь хувиа бодсон “жалга, гууны” үзэл давамгайлсан үндэстэн байх гэж хэлж ч болмоор. Тэр ч байтугай “монголчууд тамын тогоонд орчихвол өөд гарсан нэгийгээ дарсаар “өөд” болох ёстой” мэт яриа олны дунд байдаг. Энэ бол хар амиа бодох муу санааг жигшүүлэх түүнийг үзэн ядах үзлээр залуу үеийг хүмүүжүүлэх утга санаагаар үүссэн яриа ч байж болно. Яагаад гавэл, монгол айл бол айл саахалтын, хот айлын, хамаатан садан, ураг төрлийн холбоо хүчтэй хөгжсөн улс орны нэг юм. Хамаатан садан ах дүүгээ, хөгшид настангуудаа асарч өргөх нь бичигдээгүй “хууль” байдаг төдийгүй ерөөс садан биш ч гэсэн хөгшин залуу ядарч доройтсон, доройтоогүй айл хөршийхөндөө чадах бүхнээрээ тус дэм болж ирсэн уламжлалтай улс орон билээ. Хөгшин настай ядарч зүдэрсэн айл өрхийг ганц нэгээр нь ялгаварлан орхихгүй харин ч цайны сүү, идээ будаатай эргэж тойрч, орж гарч байдаг ёс жаяг монголын аль ч нутаг усанд өргөн дэлгэр бий.

Монголчуудын хувьд бие биедээ туслах уламжлалт харилцаа бусад зарим оронд байдгийн адил онцлогтой байжээ. Эдүгээ хэн ч гэсэн тусламж дэмжлэг үзүүлснийхээ болон үйлчилгээний хөдөлмөрийнхөө хариуг “мөнгө” эсвэл таваараар тооцдог бол манайд тийм байсангүй ээ.

Америкийн социолгич Нейл Смелзер “Америкийн нийгэм бол таваар үйлчилгээ, мөнгөний харилцаанд тулгуурласан зах зээлийн эдийн засагт тулгуурласан нийгэм юм. Улс төрийн, эдийн засгийн сэтгэлгээ сүүлийн хоёр зууны турш харилцааны энэ төрлийг авч үзсээр ирлээ. Зах зээлийн эдийн засаг бол эдийн засгийн үйл ажиллагааг зохион байгуулах цорын ганц арга хэлбэр нь гэж үзэж болох хэдий боловч яг энэ үзлийг хатуу баримталвал алдаанд хүрнэ. Бид түүнийг хэт товойлгон алагчлахгүйгээр /шинжилвэл/ ажиглавал түүнд байгаа олон ялгааг харж болно” гээд Шинэ Гвинейн нэг овгийнхны эдийн засгийн үйл амьдралыг 1920-оод оны эхээр анх удаа судалсан Бронислав Малиновскийн ажиглалтаар тэр овгийнхны дунд үйлдвэрлэлийн харилцаа нь овгийн удирдагчийн захиргаа буюу садан төрөл ах дүүгийн харилцаанд тулгуурласан байдаг гэсэн дүгнэлтийг эш татсан байдаг юм.

Гэтэл манайд бие биедээ туслах харилцаа ямар улбаа үндэстэй байв гэдгийг нарийн судалвал үе үедээ өвөрмөц, сонин холбоо хамаарал ажиглагдах нь дамжиггүй. Ямар ч гэсэн бидний мэдэж байгаагаар монголчуудын бие биендээ туслах харилцааны төрөл хэлбэр, агуулгын хувьд нилээд өргөн байсан бололтой юм. Энэ нь юуны өмнө нэг айл-өрхийн

гишүүдийн хүчин чармайлт мөхөсдөхөөр ажил, үйлийг хамтарч гүйцэтгэхэд чиглэгдэж байжээ.

Айл сахалтынхандаа энэ зорилгоор тодорхой цаг хугацаа зарж зүтгэсний хөлс хариуг шууд “тооцдоггүй” онцлогтой. Ажил үйлсэд нь тус дэмжлэг үзүүлсэн хүнд, өөрт нь мөн тийм шаардлага гарах үед айл хөршийнхөн нь эргэж тус хүргэдэг бичигдээгүй хууль үйлчилж байсан гэж үзэх бүрэн үндэстэй. Тийм ч учраас монголчуудын “аяганы хариу өдөртөө агтны хариу жилдээ” гэж ярьдаг нь энэ утга санааны илэрхийлэл гэж үзэлтэй.

Бие биедээ үзүүлэх туслалцаа мал аж ахуйн хүнд хүчир хөдөлмөрт төдийгүй байгаль цаг уурын бэрхшээл саадыг даван туулахад ч нэгэн адил илрэлээ олдог байжээ. Монголчуудын бие биедээ үзүүлэх тусламж дэмжлэг нь магадгүй тэдний ажил хөдөлмөрийн, амьдрал үйл ажиллагааны гол түлхэц хүчин зүйл нь болж ирсэн онцгой ач холбогдол бүхий харилцааны өндөр соёл байсан гэж үзэх бүрэн үндэстэй юм.

Шинэ гэр барих, эсгий хийх, нүүдэл суудал хийх, хашаа хороо барих, түлээ түлш, хоол хүнсээ базаах болон уналга ачлаганы мал тэрэг, чаргаараа бие биедээ туслалцахаас эхлээд өдөр тутмын дутагдсан гачигдсан зүйлийг ч өгөлцдөг, авалцдаг өргөн хүрээтэй үйл ажиллагаа нийгмээс тогтоогдсон ямар нэгэн хууль, дүрэмгүйгээр мөрдөгддөг байсан байна. Тэр ч байтугай зарим үйл ажиллагаа нь ардын ёс заншил болон уламжлагдан үлдсэн байдаг. Жишээлвэл: Хол нүүдэл хийж яваа айлыг танихгүй ч байсан гэсэн тавагтай идээ, данхтай цайгаа барьсаар утгаж хөдөө хээр цайлуулаад сайн явж нүүдэллэхийг ерөөгөөд үлдэг уламжлал болсон ёс горим өөр оронд хаана ч үгүй байх.

“Айл хүний амь нэг”, “Сахалт хүний санаа нэг”, “Дэм дэмэндээ, дээс эрчиндээ” гэдэг утга яруу төгөлдөр, цэцэн үгс бол бол санаандгүй хэлэгдэж ардын ярианы хэвшмэл хэллэг болж амьдралд мөрдөгдөөгүй гэдэг нь хэн бүхэнд ойлгогчтой юм.

Энэ бэсрэгхэн өгүүлэлд миний хувьд дэвшүүлэх гэсэн гол санаа бол:

Нэгдүгээрт, аль ч оронд хүмүүсийн хооронд байдаг /общения/ харилцааны онцлог хэлбэр болох харилцан бие биенээ дэмжин туслах энэ хэлбэр монголд түлхүү хөгжиж ирснийг тэмдэглэхийн ялдамд тэр нь бусад зарим оронд байдаг шиг зөвхөн садан төрлийн буюу овгийн ахлагч /хошуу ноён/ захирагдах харилцаагаар биш айл сахалтынхны олон нийтийн хараа хяналтын доор хүүхэд ахуй цагаас нь дадал зуршил болж улмаар бие хүний зайлшгүй гүйцэтгэн мөрдөж байх ёс суртахууны норм хэмжээ болох түвшинд мөрдөгдөж байжээ гэдгийг, хоёрдугаарт: монголчуудын харилцан бие бие хүндлэх тус дэм үзүүлдэг зан харилцааны дэвшилтэт энэ сайхан уламжлал сүүлийн үед мартагдаж үгүйлэгдэх болсныг тэмдэглэхийн зэрэгцээгээр түүний учир шалтгааныг тодруулан засч залруулахад социологичид- уншигч авхай нарын анхаарлыг хандуулахад оршино.

Монголчуудын дунд хэвшил болсон зан харилцааны дээр дурдсан дэвшилтэт харилцаа бол тэдний эрхэлдэг байсан хувийн аж ахуй хөдөлмөрийн онцлогтой холбоотой байсан. Эдүгээ малчин мал хоёрын харилцаа ихээхэн өөрчлөгдсөн гэж хэлэх үндэстэй гэж бодож байна. Нэгдэлжих хөдөлгөөний үед малыг сэтгэл зүрхээрээ хариуцан түүнд хүч чадал оюун ухаанаа зориулах чин эрмэлзэлтэй /ёс суртахуунтай / бүхэл бүтэн үе тасарсан гэж үзэж болно. Нэгдэл, нийгмийн мал гэсэн сэтгэл зүй малчны хөдөлмөрийг “хүнийсгэл” /отчуждение/- ийн хөдөлмөр болгон улмаар тэдний ёс суртахууныг өөрчлөхөд нөлөөлсөн. Энд мөн хөдөлмөрчдийн шашингүйн үзлийн нөлөө ч ихээхэн учир холбогдолтойг дурьдах хэрэгтэй юм.

Макс Вебер “Протестант ёс зүй ба Капитализмын үзэл санаа” гэдэг алдарт бүтээлдээ одоогийн капитализмыг архагшсан капитализм гэж нэрлээд энэ нийгмийг тэтгэн тэжээж хөлс хүчээ зориулах хувь тавилан бүхий иргэдийг аль урьд үед нь бэлтгэсэн гэсэн санааг дэвшүүлсэн байдаг. Энэ бол нийгмийн түүхийн аль нэг үеийг авч явах ёс зүйтэй иргэдийг бэлтгэх л хамгийн гол асуудал болохыг цохон тэмдэглэсэн нь юм.

Эцэст нь тэмдэглэхэд: Монголчуудын бие биедээ тусалж хөдөлмөрөө хоршиж ирсэн эл уламжлалт харилцааг одоо үед хөгжүүлэх асуудал нэн чухлаар тавигдаж байна. Өөрөөр хэлбэл, ард түмний дунд бие биедээ чин сэтгэлээр туслах ялангуяа, амьдралын шинэ нөхцөл

байдалд идээшиж хөлөө олоход туслах буяны хөдөлгөөнийг үүсгэх байгууллага, мэргэжлийн хүмүүс шаардагдаж байна.

Ийм шаардлагыг харгалзан Английн хүүхдийг ивээх сангийн санаачлагаар 1997 онд Монголд анх удаагаа Улаанбаатар Их Сургуульд нийгмийн ажилтныг бэлтгэх салбар нээсэн, дараа нь ТИС-д, өнгөрсөн хичээлийн жилд МУИС тус тус ийм мэргэжилтнийг бэлтгэж эхэллээ. Мөн хувийн хэд хэдэн сургууль ч ийм сургалт явуулж байгаа. Тэгэхээр нийгмийн ажилтан гэдэг мэргэжлийг бий болголоо гэхэд түүнийг хүлээж авах нийгмийн орчин ямар вэ гэдгийг л ихээхэн бодолцох ёстой. Энэ чухал бөгөөд “шинэлэг” мэргэжил, мэргэжилтнийг дэмжин хүлээж авах, нөгөө талаар уг үйл хэрэг маань өөрийнхөө оршин тогтнох үндэс сууриа өөрөө нөхөн үржүүлдэг байх ёстойг л ихээхэн анхаарах ёстой юм.

Өмнө өгүүлсэнчлэн “хуучин” мөртөө “шинэлэг” харилцааг манай нийгмийн өнөөгийн амьдралд түгээн дэлгэрүүлж амьд биелэл болгох хувь тавилантай мэргэжлийн хүмүүс бол өнөөдрийн нийгмийн ажлын ангийн оюутнууд юм.